Тамхинаас гаргах цитизин эм, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүн

Д.Мөнх-Учрал[1], М.Еркебулан[1], Н.Гүнчмаа[1], Ч.Аззаяа[1], Н.Надмидцэрэн[1], Ц.Мөнхнасан[1], М.Сугармаа[1], Т.Ганцэцэг[2], С.Хандмаа[3], Д.Даваалхам[1]

[1]АШУУИС, Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
[2]АШУУИС, Анагаах Ухааны Сургууль
[3]АШУУИС, Багшийн хөгжил, цахим сургалтын газар
Цахим шуудан: Munkhuchral.d@mnums.edu.mn, Утас: 99002562

Түлхүүр үг:

Тамхи
Никотины хамаарал
Цитизин
Никотин орлуулах наалт

Товч утга

Үндэслэл: Дэлхий дахинд 1.1 тэрбум хүн тамхи татаж, тамхины шалтгаант нас баралтын тохиолдол 8 сая бүртгэгддэг. Монгол улсын хэмжээнд нийт хүн амын 27.1 хувь нь тамхи татдаг. Тамхи татдаг иргэдийн 50 хувь нь тамхинаас гарах оролдлого хийж үзсэн байдагч 3/1 нь л нотолгоонд суурилсан тамхинаас гаргах тусламж авч, 10 хүн тутмын 1 нь тамхинаас гардаг байна. **Зорилго:** Тамхинаас гаргах цитизин (Табекс) эмийн эмчилгээ, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг үнэлэх. **Арга, аргачлал:** Судалгааны загвар: Эмнэлэгт суурилсан, дан нууцлалтай, эмнэлзүйн туршилт судалгаа 1611 хүн тамхинаас гаргах эмчилгээг сонирхож ирсэн. Үүнээс судалгааны үндсэн шалгуур хангасан 1250 хүнд тамхины хор уршгийн талаар зөвлөгөө өгч 958 хүн тамхинаас гарахыг зөвшөөрсөн. Үүнээс 80 хүн эсрэг заалтаар, эмчийн дүгнэлтээр судалгаанаас хасагдаж 875 хүн судалгааг эхлүүлсэн. Эм, наалт эмчилгээний бүлэгт оролцогчдод 25-28 хоног хэрэглэх, нэг курс эмчилгээний цитизин (табекс) эм, никотин орлуулах наалтыг 14 хоногийн тунгаар 2 удаа олгосон. **Үр дүн:** Судалгаанд оролцогчид дунджаар 19.1±6.8 настайдаа тамхи татаж эхэлсэн, тамхи татсан дундаж хугацаа 23.7±11.8 жил, өдөрт татдаг тамхины тоо дунджаар 15.3±7 ширхэг байсан. Эмийн эмчилгээний бүлэгт оролцогчдын 245 (58.2%), наалт эмчилгээний бүлэгт 218 (48%) огт тамхи татаагүй байна. Эмийн эмчилгээний бүлгийн үр дүнг наалт эмчилгээний бүлэгтэй харьцуулахад эмийн үр дүн 10.2 нэгжээр өндөр ($p<0.001$) тодорхойлогдсон. Никотины хамаарлын түвшин, эмчилгээний үр дүн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ($p<0.09$) ажиглагдаагүй.**Дүгнэлт:** Цитизин эм никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнтэй харьцуулахад 10.2 нэгж илүү үр дүнтэй ($p<0.001$) байна.

Үндэслэл: 2022 оны байдлаар дэлхийд 1.3 тэрбум хүн буюу насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь буюу эрэгтэйчүүдийн 36.7 хувь, эмэгтэйчүүдийн 7.8 хувь нь тамхи татаж байна.[1,2] ДЭМБ-ийн мэдээлснээр нийт хүн амын 22.3 хувь нь тамхи татдаг бөгөөд тамхины шалтгаант нас баралтын тохиолдол жил бүр 8 сая бүртгэгдэж үүнээс 7 сая гаруй тамхичид байдаг бол 1.2 сая орчим нь дам тамхидалтад өртөж буй иргэд байна.[1] 2019 оны байдлаар Монгол улсад тамхины шалтгаант нас баралт 100.000 хүн амд 166.6 тохиолдож, Дэлхийн нийт 195 улсаас өвчлөл, нас баралтын тохиолдол өндөр эхний 10 багтаж байна.[2] Монгол улсын хэмжээнд нийт хүн амын 27.1 хувь нь буюу 2 эрэгтэй тутмын 1, харин эмэгтэйчүүдийн хувьд 20 эмэгтэй тутмын 1 нь тамхи татаж байна.[2,3]

Тамхи татдаг иргэдийн 2/3 нь тамхинаас гарах хүсэлтэй байдаг ч ойролцоогоор 50 хувь нь тамхинаас гарах оролдлого хийж үзсэн байдаг ажээ.[1] Харамсалтай нь тамхинаас гарах оролдлого хийсэн иргэдийн 1/3 нь л нотолгоонд суурилсан тамхинаас гаргах тусламж үйлчилгээ авдаг бөгөөд эдгээр хүмүүсээс 1/10 нь л тамхинаас амжилттай гарч чаддаг байна.[1]

Зорилго: Тамхинаас гаргах цитизин (Табекс) эмийн эмчилгээ, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг үнэлэх.

Зорилт:

1. Тамхинаас гаргах цитизин (Табекс) эмийн эмчилгээний үр дүнг үнэлэх

2. Тамхинаас гаргах никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг үнэлэх.
3. Тамхинаас гаргах цитизин (Табекс) эм, никотин орлуулах наалт эмчилгээний харьцуулах

Арга, аргачлал: Тамхинаас гаргах цитизин (Табекс) эм, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг үнэлэхэд эмнэлэгт суурилсан, дан нууцлалтай эмнэлзүйн туршилт судалгааны загварыг ашигласан.


Хамрах хүрээ, түүвэрлэлт: Эмнэлзүйн туршилт судалгаа 2022 оны 02 сарын 01-ээс 2022 оны 06 сарын 01-ний хооронд үргэлжилсэн. Эмчилгээний нэг бүлэгт 350 хүн буюу нийт 700 хүнд үр дүн тооцохоор төлөвлөсөн.

Хүснэгт 1. Судалгааны түүвэр (Дүүргээр)

Дүүрэг	Нийт хүн ам (18-65 хүртэлх настай)	Суурь үнэлгээ	Эмчилгээ эхлүүлсэн	Бүрэн дууссан
Баянзүрх	230.125	269	197	162
Сонгинохайрхан	202.652	216	173	125
Баянгол	130.160	226	140	102
Хан-Уул	121.296	221	144	133
Чингэлтэй	85.313	167	116	98
Сүхбаатар	86.353	151	105	80
Нийт	**855.899**	**1250**	**875**	**700**

Судалгаанд хамруулах шалгуур:
- Тамхинаас гарах хүсэлтэй (Өдөрт 5–иас доошгүй тамхи татдаг)
- 18 – 65 хүртэлх насны Монгол улсын иргэн
- Коронавирусийн эсрэг вакцины 2–иос доошгүй тунд хамрагдсан эсвэл халдвар авч эдгэрснээс хойш 1 сараас доошгүй хугацаа өнгөрсөн байх
- Эрүүл мэндийн даатгал төлдөг, судалгааны явцад утсаар харилцах боломжтой


Судалгаанаас хасах шалгуур: Судалгаанаас жирэмсэн болон хөхүүл, тамхинаас гаргах бусад төрлийн эмчилгээнд хамрагдаж байгаа, дараах өвчний оношн тавигдсан тохиолдолд судалгаанаас хассан.
- Зүрхний цус хомстох өвчин, зүрхний дутагдал, даралт ихсэлт, тархины судасны эмгэгүүд, цусны судасны бөглөрөлт өвчин
- Бамбай булчирхайн гормоны ялгаралт ихсэх, чихрийн шижин, элэг, бөөрний дутагдал, бөөрний булчирхайн хромаффин эсийн хавдар
- Ходоод, улаан хоолойн сөргөө өвчин, ходоод гэдэсний идэгдмэл шархлаа өвчин, арьс харшлын гаралтай суурь өвчтэй, сэтгэцийн эмгэгүүд зэрэг болно.



Зураг 1. Туршилт судалгааны хуваарилалт


Тамхинаас гаргах эмчилгээний тухай мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр дамжуулан давхардсан тоогоор 23107 иргэнд мэдээллийг хүргэснээс 1611 хүн тамхинаас гаргах эмчилгээг сонирхож ирсэн. Үүнээс судалгааны үндсэн шалгуур хангасан 1250 хүнд тамхины хор уршгийн талаар зөвлөгөө өгч 958 хүн тамхинаас гарахыг зөвшөөрсөн. Үүнээс 329 хүн тамхинаас гарах эмчилгээнд оролцохоор хандсан бөгөөд 80 эсрэг заалтаар, эмчийн дүгнэлтээр судалгаанаас хасагдаж 875 хүн судалгааг эхлүүлсэн. Эмчилгээнд оролцогчдыг туршилтын буюу цитизин (табекс) эм, хяналтын буюу никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгт санамсаргүй (бүлгийн харьцаа 1:1) хуваарилсан.

Эмийн эмчилгээний бүлэг (Цитизин (Табекс) эм): Эмийн эмчилгээний бүлэгт оролцогчдод 25 өдөр хэрэглэх, нэг курс эмчилгээний цитизин (табекс) эмийг 14 хоногийн тунгаар 2 удаа олгосон.



Зураг 2. Эмийн эмчилгээний бүлгийн эмчилгээний тун, хяналтын үргэлжлэх хугацаа

Никотин орлуулах наалт эмчилгээний бүлэг: Никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгт оролцогчдод 28 өдөр хэрэглэх, нэг курс эмчилгээний арьсны наалтыг 14 хоногийн тунгаар 2 удаа олгосон.



Зураг 3. Никотин орлуулах наалт эмчилгээний бүлгийн эмчилгээний тун, хяналтын үргэлжлэх хугацаа

Судалгааны хэрэглэгдэхүүн: Тамхинаас гаргах цитизин (Табекс) эмийн эмчилгээ, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнг тооцож, зан үйлийг өөрчлөх интервенцийн үзүүлэх нөлөөг судлахын тулд 6 бүлэг 60 асуулттай асуумж ашигласан.

- Тамхины хэрэглээ
- Никотины хамаарлын фагерстром үнэлгээний асуумж (FTND)
- Цитизин (Табекс) эм, никотин орлуулах наалтын хэрэглээ
- Табекс, никотин орлуулах наалт эмчилгээний гаж нөлөө
- Архины хэрэглээг үнэлэх AUDIT асуумж
- Тамхинаас гарах бэлэн байдлын үнэлгээ

Ёс зүйн асуудал: 2021 оны 11 сарын 19-нд АШУУИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын Хорооны хурлаар (2021/3-12) судалгааны ёс зүйн зөвшөөрөл авч судалгааг эхлүүлсэн.

Статистик боловсруулалт: P утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадлалтай гэж үзнэ. Хувиар илэрхийлэгдсэн хувьсагчдад Пирсоны хи квадратын арга (Pearson's Chi-square test), Фишер эксакт тестийн (Fisher exact test) аргуудыг ашигласан. Хэрэв p утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадлалтай гэж үзсэн.

Үр дүн: 1611 хүн тамхинаас гаргах эмчилгээг сонирхож Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн ЭМТ-ийн сэтгэц, донтолтын кабинетад хандсан. Үүнээс судалгааны үндсэн шалгуур хангасан 1250 хүнд тамхины хор уршгийн талаар зөвлөгөө өгч 958 хүн тамхинаас гарахыг зөвшөөрсөн бөгөөд 83 хүн эсрэг заалтаар эмчийн дүгнэлтээр хасагдаж 875 хүн эмчилгээг эхлүүлсэн. Харин 292 (23.4%) нь тамхинаас гарах шийдвэр гаргаагүй байна. Тамхинаас гаргах эмчилгээнд 18-65 хүртэлх насны нийт 875 (100%) хүн хамрагдсан бөгөөд хүйсийн хувьд 650 (74.3%) эрэгтэй, 225 (25.7%) нь эмэгтэй, дундаж нас 44.3±11.9 жил байсан. Судалгаанд оролцогчдын никотины хамаарлын түвшин 134 (15.3%) нь маш бага, 234 (26.7%) нь бага , 138 (15.8%) дунд , 270 (30.9%) нь их , 99 (11.3%) маш өндөр байсан ба никотины хамаарлын түвшин хүйс болон эмчилгээний бүлгийн хувьд ялгаа ажиглагдсангүй.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдагсдын тамхины хэрэглээний давтамж


Үзүүлэлт	Нийт		Хүйс			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Дундаж	С.Х	Дундаж	С.Х	Дундаж	С.Х
Тамхи татаж эхэлсэн нас	19.1	6.8	17.6	5.8	23.4	7.6
Тамхи татсан жил	23.7	11.8	24.4	12.4	21.6	9.7
Өдөр бүр татаж эхэлсан нас	20.9	7.3	19.3	6.1	25.4	8.5
Өдөрт татдаг тамхины тоо	15.3	7	15.8	7	13.6	6.7

Судалгаанд оролцогчид дунджаар 19.1±6.8 настайдаа тамхи татаж эхэлсэн бөгөөд хүйсээр нь харьцуулахад эрэгтэйчүүд эсрэг хүйсээс 5.8 жилийн өмнө буюу 17.6 насандаа, эмэгтэйчүүд 23.4 настайдаа тамхи татаж эхэлсэн байна. Тамхи татсан дундаж хугацаа 23.7±11.8 жил, хүйсээр харьцуулж үзэхэд эрэгтэйчүүд эсрэг хүйсээс 2.8 жилийн их байна. Харин өдөр бүр тамхи татаж эхэлсэн нас 20.9±7.3 жил, эрэгтэйчүүд эсрэг хүйсээс 6.1 жилийн өмнөөс өдөр бүр тамхи татаж эхэлсэн байна. Өдөрт татдаг тамхины тоо дунджаар 15.3±7 ширхэг, эрэгтэйчүүд өдөрт дунджаар 15.8 ширхэг, эмэгтэйчүүд 13.6 ширхэг байсан.

Хүснэгт 3. Тамхинаас гарах оролдлого хийсэн байдал

Үзүүлэлт	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй		P утга
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
Тамхинаас гарах оролдлого хийсэн эсэх							.023
Тийм	638	72.9	487	74.9	151	67.1	
Үгүй	237	27.1	163	25.1	74	32.9	
Мэдэхгүй	228	26.1	183	28.2	45	20	

Судалгаанд оролцогчдын 638 (72.9%) нь тамхинаас гарах оролдлого хийж байсан бол, 228 (26.1%) нь мэдэхгүй, 237 (27.1%) нь тамхинаас гарах оролдлого хийж байгаагүй байна. Судалгаанд оролцогчид урьд нь 2.4±1.5 удаа тамхинаас гарах оролдлого хийж байсан байна. Хүйсээр нь харьцуулж үзэхэд эрэгтэйчүүд 2.3±1.5 удаа, эмэгтэйчүүд 2.5±1.5 удаа тамхинаас гарах оролдлого хийсэн байна. Харин тамхи татахгүй тэвчсэн дундаж хугацаа 7.1±18.5 сар, эрэгтэйчүүд 7.8±20.4 сар, эмэгтэйчүүд 4.5±9.6 сар тамхи татахгүй тэвчсэн байна.



Зураг 4. Тамхинаас гарах бэлэн байдлын үнэлгээ

Бэлэн байдлын онооны дундаж эмчилгээ эхлэх өдөр 9.44 байсан. Харин үзүүлэлт тус бүрээр задалж үзвэл тамхинаас гарахыг чухалд тооцож буй оноо хамгийн өндөр (9.66), итгэлтэй байдал (9.03) хамгийн бага байна.

Хүснэгт 4. Цитизин (Табекс) эм, наалтыг зааврын дагуу хэрэглэсэн эсэх

Үзүүлэлт	Нийт		Эм		Наалт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Эмчилгээ тус болж байсан эсэх						
Тийм	695	97.7	335	99.4	360	96
Үгүй	17	2.3	2	0.6	15	4
Эмчилгээг зааврын дагуу хэрэглэсэн байдал						
Байнга	580	82.8	273	81.7	307	83.9
Заримдаа	103	14.8	53	15.9	50	13.7
Огт үгүй	17	2.45	8	2.4	9	2.5

Эмчилгээнд оролцогчдын 273 (81.7%) нь зааврын дагуу, 53 (15.9%) нь заримдаа, 8 (2.4%) нь огт үгүй гэж хариулсан байна. Зааврын дагуу хэрэглээгүй шалтгааныг тодруулахад 47 (77%) нь мартсан, 4 (6.6%) нь тамхинаас гарах итгэл төрөөгүй гэж хариулсан байна (Хүснэгт 4).

Хүснэгт 5. Эм, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүн

Үзүүлэлт	Нийт	Огт тамхи татаагүй		Тамхи татсан, гэхдээ урьдынхаас багассан		Урьдын адил татаж байгаа		P утга
	n	n (%)	95% и.и.	n (%)	95% и.и.	n (%)	95% и.и.	
Эмчилгээний бүлэг								**0.001**
Эм	421	245 (58.2)	53.4-62.8	86 (20.4)	16.8-24.5	90 (21.4)	17.7-25.5	
Наалт	454	218 (48)	43.4-52.6	140 (30.8)	26.7-35.2	96 (21.1)	17.6-25.1	
Никотины хамраалын түвшин								0.09
Маш бага	134	81 (60.4)	52-68.4	33 (24.6)	17.9-32.4	20 (14.9)	9.7-21.7	
Бага	234	130 (55.6)	49.2 - 61.8	60 (25.6)	20.4-31.5	44 (18.8)	14.2 - 24.2	
Дунд	138	73 (52.9)	44.6 - 61.1	38 (27.5)	20.6-35.4	27 (19.6)	13.6 - 26.8	
Их	270	135 (50)	44.1 - 55.9	72 (26.7)	21.7-32.2	63 (23.3)	18.6 - 28.6	
Маш өндөр	99	44 (44.4)	34.9 - 54.3	23 (23.2)	15.8-32.2	32 (32.3)	23.7 - 41.9	
Архины хэрэглээ								0.216
Эрсдэл бага	621	327 (52.7)	48.7 - 56.6	155 (25)	21.7-28.5	139 (22.4)	19.2-25.8	
Аюултай	186	105 (56.5)	49.3 - 63.4	47 (25.3)	19.4-31.9	34 (18.3)	13.2-24.3	
Хортой үр дагавартай	37	18 (48.6)	33.2 - 64.3	10 (27)	14.8-42.7	9 (24.3)	12.8- 39.7	
Архины хамааралтай	31	13 (41.9)	25.9 - 59.4	14 (45.2)	14 (45.2)	4 (12.9)	4.5-27.8	

Эмийн эмчилгээний бүлэгт оролцогчдын 245 (58.2%), наалт эмчилгээний бүлэгт 218 (48%) огт тамхи татаагүй байна. Эмийн эмчилгээний бүлгийн үр дүнг наалт эмчилгээний бүлэгтэй харьцуулахад эмийн үр дүн 10.2 нэгжээр өндөр (p<0.001) тодорхойлогдсон.

Эмчилгээний үр дүнг никотины хамаарлын түвшинтэй харьцуулж үзэхэд никотины хамаарлын түвшин нэмэгдэх тусам огт тамхи татаагүй, татсан гэхдээ урьдынхаас хэрэглээгээ бууруулсан хувь буурч байгаач статистик ач холбогдол бүхий ялгаа (p<0.09) ажиглагдсангүй.

Архины хэрэглээтэй нь холбож үзэхэд архины хамаарлын түвшин нэмэгдэх тусам огт тамхи татаагүй, татсан гэхдээ урьдынхаас хэрэглээгээ бууруулсан хувь буурч байгаач статистик ач холбогдол бүхий ялгаа (p<0.216) ажиглагдсангүй.

Эмийн эмчилгээний бүлэгт 62 (16.5%) нь ханилгах, 61 (18.1%) нь хоолны дуршил нэмэгдэх, 61 (18.1%) нь зөвхөн эмэгтэйчүүдэд сарын тэмдгийн мөчлөг өөрчлөгдөх, 58 (17.2%) нь ам хуурайших, 48 (14.2%) нь дотор муухайрах, 44 (13.1%) шүлс асгарах, 40 (11.9%) даралт ихсэх, 40 (11.9%) цээж хорсох, 40 (11.9%) нь бие сулрах, хөлрөх, 26 (7.7%) зүрхний цохилт олшрох зэрэг эмийн гаж нөлөө нийтлэг тохиолдсон байна.

Никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгт 93 (24.8%) хэсэг газар загатнах, 62 (16.5%) ханиалгах, 53 (14.1%) үнэрлэх амтлах мэдрэхүй өөрчлөгдөх, 53 (14.1%) ам хуурайших, буйл үрэвсэх, 44 (11.7%) шүлс асгарах, 39 (10.4%) дотор муухайрах, 38 (11.4%) хоолны дуршил нэмэгдэх зэрэг наалтын гаж нөлөө илэрсэн байна. Эмчилгээний явцад тохиолдох дээрх гаж нөлөө нь эмчилгээний 14 дахь хоногоос 28 дахь хоногт буурсан үзүүлэлттэй байна.

Хэлцэмж: Бидний судалгааны эмийн эмчилгээний бүлэгт оролцогчдын 245 (58.2%), наалт эмчилгээний бүлэгт 218 (48%) огт тамхи татаагүй байна. Эмийн эмчилгээний бүлгийн үр дүнг наалт эмчилгээний бүлэгтэй харьцуулахад эмийн үр дүн 10.2 нэгжээр өндөр (p<0.001) тодорхойлогдсон.

Н.Валкэр, К.Хоби нарын 2011-2013 оны хооронд хийгдсэн “Тамхинаас гаргах цитизин эм, никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнгийн судалгаанд оролцогчид эмчилгээний эхний 7 хоногт эмийн бүлгээс тамхинаас гарсан байдал 60 хувь (n=655-394), наалт бүлгээс тамхинаас гарсан байдал (n=655-303) бол 30 дахь хоногт эмийн бүлгээс 40 хувь (n=655-264), наалт эмчилгээний бүлгээс тамхинаас гарсан байдал 31 хувь (n=655-203) тамхинаас гарсан байгаа нь эмчилгээний 30 дахь хоногийн үр дүн ялгаатай байна.[4] Тухайлбал Н.Валкэр, К.Хоби нарын нарын судалгаанд эмчилгээний 30 дахь хоногт 35.5 тамхинаас гарсан бол бидний судалгаанд оролцогчдын 53.1 хувь нь тамхинаас гарсан байна.[4]

Дүгнэлт:

1. Цитизин эмийн бүлэгт оролцогчдын 245 (58.2%) нь тамхинаас гарсан байна.
2. Никотин орлуулах наалт эмчилгээний бүлэгт оролцогчдын 218 (48%) нь тамхинаас гарсан байна.
3. Цитизин эм никотин орлуулах наалт эмчилгээний үр дүнтэй харьцуулахад 10.2 нэгж илүү үр дүнтэй (p<0.001) байна.

Талархал: Судалгаа хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн АНУ-ын Лома Линдагийн их сургууль, аргазүйн дэмжлэг үзүүлсэн АШУУИС, НЭМС-ийн хамт олон “Тамхинаас гаргах эмийн эмчилгээ, зан үйлийг өөрчлөх интервенцийн төсөл”-ийн багийн хамт олонд талархсанаа илэрхийлье.

Ном зүй:

1. *П.Энх-Учрал, Т.Ганцэцэг, Марелиз, Эндрью. Тамхинаас гарах хөтөлбөрийн үр дүн. Хүрэл тогоот – 2019:194-203*
2. *ЭМЯ, НЭМТ, ДЭМБ. Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын дөрөвдүгээр судалгаа – 2019. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг: 2019.*
3. *Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт. Улаанбаатар 2021: 174-175*
4. *Walker N, Howe C, Glover M, McRobbie H, Barnes J, Nosa V, Parag V, Bassett B, Bullen C. Cytisine versus nicotine for smoking cessation. N Engl J Med. 2014 Dec 18;371(25):2353-62. doi: 10.1056/NEJMoa1407764.*
5. *Монгол улсын стандарт. Тамхины хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношлогоо, эмчилгээ F17 MNS 5396-2:2018. Улаанбаатар: Үндэсний стандарт хэмжилзүйн газар: 2018*
6. *Монгол Улс. Төрийн мэдээлэл. Тамхины хяналтын тухай хууль шинэчилсэн найруулга. Улаанбаата: Засгийн газрын дэргэдэх хэвлэх үйлдвэр. 2019.*
7. *Tobacco Control Office Department of Health. Smoking cessation information kit. Hon Kong: 2015*
8. *Cahill K, Lindson-Hawley N, Thomas KH, Fanshawe TR, Lancaster T. Nicotine receptor partial agonists for smoking cessation. Cochrane Database Syst Rev. 2016 May 9;(5):CD006103. doi: 10.1002/14651858.CD006103.pub7. Review.*

Effects of cytisine tablet and nicotine replacement patch for smoking cessation

Munkh-Uchral D[1], Yerkyebulan M[1], Gunchmaa N[1], Azzaya Ch[1], Nadmidtseren N[1], Munkhnasan Ts[1], Sugarmaa M[1], Gantsetseg T[2], Khandmaa S[3], Davaalkham D[1]*

[1]MNUMS, School of Public Health
[2]MNUMS, School of Medicine
[3] MNUMS, Division for Teacher Development and E-Learning
E-mail: Munkhuchral.d@mnums.edu.mn, Tel: +976-99002562

Background: There are 1.1 billion smokers worldwide and 8 million smoking-related deaths have been reported every year. In Mongolia, 27.1 percent of the total population are smokers. Of them, fifty percent have attempted to quit smoking, but only one-third of them have received evidence-based smoking cessation counseling, with a success rate of one in 10.
Materials and Methods: based on the hospital, blinded, clinical trial
A total of 1611 people showed interest in participating in the research. 1250 people have fulfilled fundamental criteria. Of those, 958 people have been included in the study. However, 875 people could have started in the research because 80 people had contraindications to treatment, which had been assured by the doctor's screening. We have been given 25-28 days of usage medication (Cytisine) and nicotine patches to use 2 times a month for both the medication group and nicotine replacement patch group.
Results: Average age of starting smoking was 19.1±6.8 years among participants, the average period of smoking was 23.7±11.8 years, average daily usage of cigarettes among participants was 15.3±7. 254 (58.2%) participants of the medication group no longer smoking, 218 (48%) participants of the nicotine patch group showed no longer smoking. When comparing the treatment and control groups, we found a 10.2% ($p<0.001$) higher success rate in the treatment group than in the control group. We have not observed any significant difference in nicotine dependence between the treatment group and the control group. ($p<0.001$)
Conclusion:

1. Cytisine treatment for smoking cessation had a 58.2 percent
2. Nicotine replacement therapy treatment for smoking cessation had a 48 percent
3. Cytisine treatment for smoking cessation had a 10.2 percent higher success rate and nicotine replacement treatment.

Keywords: Tobacco, nicotine dependence, cytisine, nicotine patches